

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН
2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжид тавьсан хоригийг хэлэлцэж хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан “Хууль тогтоомжийг хүчингүй болгосонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсан.

Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Тус тогтоолд заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд урсгал зардлыг бууруулах зохицуулалт хийхтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн орлого буурахаар байна. Иймд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

-oOo-

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжид тавьсан хоригийг хэлэлцэж хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан “Хууль тогтоомжийг хүчингүй болгосонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсан.

Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Тус тогтоолд заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд урсгал зардлыг бууруулах зохицуулалт хийхтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн орлого буурахаар байна. Иймд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн зүйл тус бүрээр:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ – Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх шинэчилсэн орлогын хэмжээг хүснэгтээр тусгасан.

2 ДУГААР ЗҮЙЛ – Энэ хуулийг батлагдсан өдрөөс хойш дагаж мөрдөнө.

Хуулийг мөрдөж эхлэх огноог тусгасан.